БАТЛАВ
Байгаль орчин, аялал жуулчлалын
газрын дарга Б.Энхтуяа

БАТЛАВ
"Нэтэнт" ХХК-ний ерөнхий
захирал А.Хилэнбаатар

# УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2023.07.03 Дугаар 06 Улаангом сум

Нэг.Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.8, 29.1-д заасан, Увс нуур-Тэсийн голын сав газрын захиргааны 2023 оны 05-р сарын 29-ний 02 дугаартай Ус ашиглуулах дүгнэлт, Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргын олгосон 2023 оны 07 дүгээр сарын 07-ны өдрийн А/09 тоот ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

**Ус ашиглуулагчийг төлөөлж**: Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Усны асуудал хариуцсан мэргэжилтэн Т.Цэрэннадмид

**Ус ашиглагчийг төлөөлж**: Увс аймаг, Улаангом сум 3-р баг, Улсын бүртгэлийн 1511002011 тоот гэрчилгээтэй, 4001621 регистрийн дугаартай "Нэтэнт" ХХК-ны гүйцэтгэх захирал А.Хилэнбаатар нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт: "Цагаан хөшөөн адаг" тоосгоны шаврын ордыг ашиглан жилд 4 сая ширхэг стандартын улаан тоосго үйлдвэрлэнэ.

2.2. Ашиглах усны хэмжээ: 4418 шоо.м

2.2.1. Унд-ахуй, $м^3$/хоног 2.2 $м^3$
2.3. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хоногт ашиглах усны хэмжээ : Гүний худгаас унд ахуйн болон үйлдвэрлэлд газрын доорх ус ашиглана. Өөрийн эх үүсвэрийн гүний худагтай. Ундарга 4.2 л/сек.
Хоногт ашиглах усны хэмжээ **62,2 $м^3$**
2.4. Байршил: "Цагаан хөшөөний адаг" тоосгоны шаврын орд нь Увс аймгийн Улаангом сумаас хойд зүгт 3 км-т, Увс нуур-Тэсийн голын сав газарт оршдог.
Ашигт малтмал газрын тосны хэрэг эрхлэх газар, -Дугаар MV-015576,
Талбайн хэмжээ 31.99га

| **Талбайн координат:** | | |
|---|---|---|
| | 1. 91° 03' 59.17'' | 49° 00' 31.81'' |
| | 2. 91° 03' 33.17'' | 49° 00' 31.81'' |
| | 3. 91° 03' 33.17'' | 49° 00' 51.82'' |
| | 4. 91° 03' 59.18'' | 49° 00' 51.82'' |

2.5. Усны барилга байгууламж: Гүний худгаас 3х1,5м-т байрлуулсан 50 тн-ын усан санд усаа нөөцөлж ашиглана..
2.6. Дамжуулах байгууламж: Худгаас 32 мм-ийн яндан хоолойгоор усан санд , усан сангаас шавар зуурах машинд 15 мм-ийн уян хоолойгоор усыг дамжуулна.
2.7. Хаягдал бохир усны хэмжээ, цэвэрлэгээний арга, түвшин: Ажиллагсадын унд ахуйн хэрэглээнд 299 $м^3$ усыг хэрэглэж ахуйн бохир усыг хөрсөнд нэвчүүлэн зайлуулна.
2.8. Байгаль орчны үнэлгээний нөхцөл: Байгаль орчны нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг 2022 онд Улаанбаатар хотын "И СИ ӨҮ СИ ТИ" ХХК хийж гүйцэтгэсэн.

2.9. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:
Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2009 оны 51/75 тоот хамтарсан тушаалаар баталсан "Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм"-ийг мөрдөж ажиллах

2.10. Ус ашигласны нийт төлбөрийн хэмжээ: 862285 төгрөг /Найман зуун жаран хоёр мянга хоёр зуун наян таван төгрөг/

Гурав. Талуудын эрх үүрэг

3.1. Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 31.1-д заасн эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Дөрөв.Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус хаях зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.

4.5.1. Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;

4.5.2. Аль нэг тат татан буугдсан бол;

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

| | |
|---|---|
| Ус ашиглуулагчийг төлөөлж: | Ус ашиглагчийг төлөөлж: |
| Т.Цэрэннадмид | Ш.Оюунгэрэл |
| /Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Усны асуудал хариуцсан мэргэжилтэн/ | / "Нэтэнт" ХХК-ны Менежер/ |
| Хаяг: Увс аймаг, Улаангом сум, 5-р баг | Хаяг: Увс аймаг, Улаангом сум, 3-р баг |